

ХУВЬ ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛД

Г.Лхагвамаа

Аюулгүй байдлын удирдлага, стратегийн
профессорын багийн профессор, доктор,
дэд профессор, хурандаа

Товч агуулга: Энэхүү өгүүллээр хүний аюулгүй байдлын асуудлыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын агуулга, аюулгүй байдлын онолын үндэслэлд тулгуурлан, хүний болон хувь хүний аюулгүй байдлын нийтлэг, ялгаатай байдлыг тогтоож тодорхойлохыг зорьсон болно.

Түлхүүр үгс: Хүний аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдал, хүний амь нас, бие махбод, эрүүл мэнд, халдашгүй байдал

Нэг. Хүний аюулгүй байдлын үзэл баримтлал, онолын үндэс

Улс орнуудад “Аюулгүй байдал” хэмээх ойлголтыг улс гүрэн бүхий л улсын хил хязгаарт заналхийлэлтэй холбон, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, хүн амын удмын санг хамгаалах, түүгээр ч барахгүй хоол хүнс, экологи, соёл зэрэг салбарын асуудлын хүрээнд авч үзэж ирсэн. Харин 1994 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс аюулгүй байдлын цөм нь улс гүрэн биш хувь хүн байх учиртайг онцолсноор “Хүний аюулгүй байдал” өнөөдөр дэлхийн хэмжээний бодлогын түлхүүр үзэл баримтлал болсон. Хүний аюулгүй байдал дайн зэвсэг бус хүний өдөр тутмын амьдрал, хүн ёсоор амьдрахтай холбоотой ойлголт мөн¹.

Хувь хүний аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг авч үзэх нь юуны түрүүнд аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах асуудалтай холбогдоно. Иймээс эдгээр ойлголтуудыг хэл зүйн /нэр томъёоны хувьд/ ба хууль зүйн хувьд хэрхэн зөв тодорхойлохоос бидний судалж буй хувь хүний аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах хамгаалах тухай ойлголт, түүний мөн чанар, бүтэц, хамрах хүрээ, онцлог шалтгаална.

Аюулгүй байдал нь “аюул”, “аюултай байдал” гэсэн ойлголтоос үүсэх бөгөөд ямар нэгэн аюул байж, тэр аюулаас үүдсэн аюултай байдал үүсч байж аюулгүй байдлыг хангах тухай асуудал яригдах нь ойлгомжтой.

“Аюул” гэдэг нь гамшиг зовлон учруулж болох хор хөнөөлтэй зүйл, юм, **“аюултай байдал”** гэдэг нь айвал зохих бэрх хэцүү байдал, хор уршиг, хөнөөл учирч болох байдал, заналхийлж буй байдал гэсэн утгыг хэл зүйн хувьд илэрхийлнэ².

Аюулгүй байдал нь бодит болон далд аюул, заналхийлэл, хор уршиг учруулж болох бусад хүчин зүйлээс хамгаалах чадвар гэж зарим эрдэмтэд тодорхойлжээ. (Webster. G. 1980)

¹ НҮБ-ын Хүний хөгжил, Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 1994 он.


² Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.УХГ.1966 он. 60 дахь тал, Н.Даш нар. Монгол хэлний тайлбар толь. УБ. Монсудар. 2014 он. 92 дах тал

Харин бидний үзэж байгаагаар аюулгүй байдал гэдэг нь аливаа болзошгүй аюул, аюулт хүчин зүйл, эрсдэлээс хамгаалагдсан байдал, түүний улмаас учирж болох хор уршгаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадвар, хор аюул учруулахгүй байх шаардлагатай арга хэмжээ авагдсан, аюул үүсгэхгүй байх нөхцлүүд урьдчилан хангагдсан байдал юм.

Эрх зүйн толь бичигт **“аюулгүй байдал** гэдгийг хууль зүйн хувьд тухайн улсад улс төрийн, эдийн засгийн ба нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх, эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, цэргийн, экологийн, мэдээлэлийн бусад шинж чанартай аюул заналхийлэлээс бие хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал гэж тодорхойлжээ³.

Дээрхээс үзэхэд аюулгүй байдал, түүнийг хангах, хамгаалах асуудал нь хамрах хүрээ түвшингээрээ улс үндэсний буюу төрийн аюулгүй байдал, нийгмийн буюу нийтийн аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдал гэсэн эрэмбэ бүхий, хоорондоо уялдаа холбоо, харилцан хамаарах гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Зураг 1. Аюулгүй байдлыг хангах, хамгаалах асуудал



Үндэсний аюулгүй байдал, түүнийг хангах нь Монгол улсын язгуур эрх ашиг сонирхол бөгөөд түүнийг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” гэсэн эрх зүйн бичиг баримтаар тодорхойлсон байдаг. Уг үзэл баримтлалд зааснаар **“Үндэсний аюулгүй байдал”** гэж Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлдэг.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1-р зүйлийн 1.2.3-д “...Үндэсний аюулгүй байдлын бодлого цогц байх бөгөөд Монгол Улсын "оршин тогтнохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал", "дотоод аюулгүй байдал", **"хүний аюулгүй байдал"**, "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал", "мэдээллийн аюулгүй байдал" харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна..." гэж заасан байна.

Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг нь хүний аюулгүй байдал юм. Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, хүнсний

³ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг.УБ. Эдмон.2008 он.54 дэх тал

аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, эд хөрөнгө, орон байрны аюулгүй нөхцлийг баталгаажуулах, гэмт хэрэг халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.

Хүний аюулгүй байдал нь оюун ухаант хүн бий болсон цагаас нийт хүн төрөлхтөний амин чухал асуудал болон тавигдаж иржээ. Хүн үүссэн цагаасаа өөрийн эсрэг заналхийлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг /аюул занал/ урьдчилан мэдэх замаар түүнээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, багасгах арга замыг эрэлхийлж ирснийг түүх гэрчилнэ ⁴.

Эрт цаг үед хүмүүсийн амь нас, бие махбодь, эрүүл мэнд болон эд хөрөнгийг хамгаалах асуудал нь хувь хүн, овог аймгийнх өөрсдийн хариуцлага болж байсан.

Аюулгүй байдлын онолын үндэс.

Нийгэмд нутаг дэвсгэрийн хуваарилалтын зарчим, хувийн өмч хөрөнгө үүссэнээр аюулгүй байдлын асуудал нь хүмүүсийн эд хөрөнгө болон өөрсдийгөө хамгаалах хамгаалалтаас илүү хамааралтай болсон хэдий ч хувь хүн болон бүлгийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтыг бий болгох үйл явц маш удаан байсан^{5 6}. Нийгэм улам хөгжихийн хирээр хүмүүсийн үйл ажиллагаанд зөвшөөрөх болон хориглох зэрэг зан үйлийн горимуудын тодорхой хэлбэрүүдийг тогтоох замаар бичмэл бус хуулиас бичмэл хууль, дүрэм эцэст нь хувийн эд хөрөнгө, амь насыг хамгаалах нийгмийн хэм хэмжээ, хууль, дүрэм журмыг сахиулах, гэмт этгээдийг илрүүлэх төрийн болон хувийн хамгаалалтын тогтолцоог бий болгосон байна⁵.

Аюулгүй байдлын онолын үндэс нь хувь хүний дараах зан байдал, төсөөлөл, итгэл үнэмшил дээр үндэслэгддэг⁷.

1. Хувь хүн учирч болох эрсдлийг тооцоолохоос өмнө өөртөө ая тухтай таатай байдлыг сонгодог нь өөрийн сайн сайхны төлөөх эрэлд үргэлж буруу шийдвэрийг гаргахад хүргэдэг.
2. Нийгмийн хяналт суларч гэмт хэрэг үйлдэгдэх тохиромжтой нөхцөл бүрдэхэд гэмт хэрэг үйлддэг.
3. Нийгэм дэх хяналтын системээс хамааралгүйгээр гэмт хэрэг ямар нэг түвшинд үйлдэгдэж байдаг.
4. Хэрэв зохих урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй бол янз бүрийн гэмт зан үйл, байгалын гамшигт үзэгдлүүдээс ихээхэн хэмжээний аюул учруулах нөхцлийг бий болгодог.

⁴ С.Жанцан. Эрүүгийн эрх зүй. УБ., 2009 он. 36 дахь тал

⁵ P.J.Ortmeier, Introduction to Security: Operation and Management, Pearson Education, Inc., 2013, p.2.

⁶ Мөн тэнд.

⁷ P.J.Ortmeier, Introduction to Security: Operation and Management, Pearson Education, Inc., 2013, p.3.

Иймээс аюулгүй байдлын удирдлага нь болзошгүй аюул заналаас зайлсхийх, урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагааны стратегийг хангах зорилготой үйлчилдэг байна.

Хүний аюулгүй байдал нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд хүний аюулгүй байдлыг хангах асуудал нь улс төр, нийгэм, соёл, эдийн засаг, эрх зүй, үзэл суртал, зохион байгуулалтын зэрэг олон хүчин зүйл, арга хэмжээг өөртөө багтаасан олон улсын болон тодорхой улс орны үндэсний механизмын хүрээнд хэрэгждэг. Энэ нь асуудал хүний эрхийн асуудал юм. Тухайлбал, хүний эрх эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбоотой байдгаар тайлбарлагдана.

Хүний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал гэсэн ойлголтууд нь хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий харилцан нөхцөлдсөн ойлголтууд юм. Хүний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын үндэс суурь нь болдог бол үндэсний аюулгүй байдал нь хувь хүний аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг, хувь хүний аюулгүй байдлыг хангах нөхцөл болж байдаг онцлогтой.

Монгол Улсад хүний аюулгүй байдал гэдэгт юуг ойлгох, түүний бүтэц, хүний аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэх механизмын талаар судалсан дорвитой бүтээл байхгүй, иж бүрэн судалгаа хийгдээгүй байна.

Гэхдээ хувь хүний аюулгүй байдал гэдэгт хувь хүн олон улсын хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжоор тодорхойлсон жам ёсны ба хууль ёсны эрх, эрх чөлөөгөө эрх тэгш, ялгаваргүйгээр, баталгаатай эдлэх, хэрэгжүүлэх замаар аз жаргалтай, эрх чөлөөтэй, аюулгүй амьдрах нөхцөл хангагдсан байхыг хэлнэ гэж тодорхойлж болох юм.

Хүний аюулгүй байдлын ойлголт, түүний мөн чанараас үзэхэд уг ойлголт нь хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, тодорхой улс оронд хүний эрх, эрх чөлөөг хэрхэн баталгаатай хангаж, хамгаалж байна, тэр хэмжээгээр хүний аюулгүй байдал баталгаатай хангагдах учиртай.

Глобальчлалын үеийн аюулгүй байдлын үзэл баримтлалын үүднээс авч үзвэл хүний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсгээс /аюулгүй байдлуудаас/ тогтоно гэж үзэж байна. Үүнд:

1. Улс төрийн аюулгүй байдал /Төр, төрийн байгууллагын зүгээс иргэний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрхийг зөрчихгүй, хязгаарлахлахгүй байх, хүний эрх эрх чөлөөг дээдэлсэн бодлого, үйл ажиллагаа явуулах, улс төрийн хувьд хувь хүний аюулгүй байдал хангагдсан байх /
2. Иргэний хувийн эрх, эрх чөлөөний буюу хувийн /амь нас, эрүүл мэнд, хувийн халдашгүй байдал/ аюулгүй байдал
3. Эдийн засгийн аюулгүй байдал буюу өмчийн /эд хөрөнгийн/ аюулгүй байдал,
4. Шинжлэх ухаан технологийн аюулгүй байдал /Техник, технологийн шинжлэх ухааны ололт амжилт, эрсдэлээс хувь хүн хамгаалагдсан байх/,

5. Мэдээлэлийн аюулгүй байдал /Захидал харилцааны нууцын халдашгүй байдал/
6. Соёл, иргэншлийн аюулгүй байдал /үндэстэн ястны тэгш эрхийг хангах, хэл, соёл, зан заншлаа хадгалах, шашин шүтэх эрхээ баталгаатай эдлэх, тэдгээртэй аюул, эрсдлээс хамгаалагдсан байх/
7. Хүн ам, удмын сангийн болон нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдал
8. Экологийн аюулгүй байдал
9. Хүнсний аюулгүй байдал зэрэг болно.

Хүний аюулгүй байдлын дээрх бүрэлдэхүүн хэсгээс хүний хувийн аюулгүй байдал гэсэн ойлголтыг авч үзье. Дээрхээс хүний аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдал гэсэн ойлголтуудын ялгагдах онцлог, харьцааг харж болохоор байна.

Бидний үзэж байгаагаар **“хувь хүний аюулгүй байдал”** гэсэн ойлголтонд хүний аюулгүй байдлын бүрэлдэхүүн болох хүний амь нас, бие махбодь, эрүүл мэндийн аюулгүй байдал, хувийн халдашгүй байдлыг хамгаалах, эд хөрөнгийн /өмчийн/ аюулгүй байдал хангах асуудлыг хамааруулах нь зүйтэй юм. Ийм онол барууны эрх зүйд, аюул байдлын салбарт нэгэнт тогтжээ.

Дүгнэлт

Монгол Улсад аюулгүй байдлын асуудлын хүрээнд ч, эрх зүйн хувьд ч хувийн аюулгүй байдал гэсэн ойлголтыг тодорхойлоогүй, нэгдмэл ойлголт бий болоогүй байна.

Хүний аюулгүй байдал нь хувийн аюулгүй байдал гэсэн ойлголтоос өргөн хүрээтэй, хүний эрх эрх чөлөө, түүний хамрах хүрээ, хэрэгжих механизмаас хамааран хоорондоо уялдаа бүхий 9 бүрэлдэхүүн хэсгээс тогтдог. Харин хувийн аюулгүй байдал нь хүний аюулгүй байдлын зөвхөн нэг хэсэг буюу хүний амь нас, бие махбодь, эрүүл мэндийн аюулгүй байдал, хувийн халдашгүй байдал, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалах гэсэн явцуу хүрээнд яригддагт тэдгээрийн харьцаа, ялгаа оршино гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- А/ Монгол хэл дээр
- НҮБ-ын Хүний хөгжил. Дэлхийн хүний хөгжлийн илтгэл. 1994 он.
- Баярчимэг Б. “МУ-ын ҮАБ-ын 1994 оны үзэл баримтлал-Аюулгүй байдлын суурь баримт бичиг”. Тусгаар тогтнол. 2011 № 3 /17/
- Жанцан С.Эрүүгийн эрх зүй УБ., 2009 он
- Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг.УБ. Эдмон.2008 он.
- Наранчимэг Н. Баатар Ч. Хүний аюулгүй байдал: Үндсэн ойлголт, эмзэг байдал. УБ., 2009
- Очирбат П. Глобалчлалын эрин дэх хүний аюулгүй байдал” сэдэвт Олон улсын бага хурлын эмхэтгэл. 2000 он. 5 дугаар сарын 8-10. МУ-ын ЗГ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Шведийн ОУ-ын хөгжлийн агентлаг, Очирбат сан.
 - Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.УХГ.1966 он.

- Даш Н.нар. Монгол хэлний тайлбар толь. УБ. Монсудар. 2014 он.
Б/ Гадаад хэл дээр
- P.J.Ortmeier, Introduction to Security: Operation and Management, Pearson Education, Inc., 2013.